

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОУНБ	Олон Улсын нисэх буудал
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БУЯНТ-УХАА БООМТ ДАХЬ ХИЛИЙН  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН АЛБАНЫ  
ДАРГА Б.ОТГОНЦЭЦЭГ ТАНАА

2020.02.20 № 06/531  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2.Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга Б.Отгонцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, норм нормативыг барьж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ноос 2020 оны 2 дугаар сарын 5-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Б энд С аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 01/56 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны үйл ажиллагааны эрхэм зорилго нь агаарын хилийн боомтоор олон улсад шуурхай, тогтмол мэдээллэх хүн, мал, амьтны өндөр эрсдэл бүхий халдварт өвчин, гадаад хорио цээрт ургамал, хортон шавж, мэрэгч нэвтрэх, дамжин тархах, эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм, хүн, мал, амьтан, ургамлын эрүүл мэнд, удмын санд сөргөөр нөлөөлөхүйц цацраг, химийн бодис, бараа, бүтээгдэхүүн орж ирэх, хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, зорчигчдын хоол, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн хяналт шалгалт, хорио цээрийн үйл ажиллагааг Монгол Улсын болон олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомж, стандартын хүрээнд хэрэгжүүлж, үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалахад оршино гэж заажээ.

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт
- Ариутгал, халдваргүйжүүлэлтийн хяналт
- Ургамал хорио цээр, чанарын хяналт
- Мал эмнэлгийн хяналт
- Хүнсний чанар, стандартын хяналт
- Эм био бэлдмэлийн хяналт
- Байгаль орчны хяналт
- Цацрагийн хяналт
- Стандарт чанарын хяналт гэсэн үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын алба нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Интерактив компанийн “Emerald 5.0” программ хангамж ашигладаг байна.

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ийн дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,210,900.7 мянган төгрөгөөс тооцон 12,109.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 20,045.1 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэлээр авсантай холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,201.4 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	23.6		-23,6
Урьдчилгаа			
Бараа материал	114,825.3	125,884.4	11,059.1
Үндсэн хөрөнгө	406,997.4	381,760.5	-25,236.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>521,846.3</b>	<b>507,644.9</b>	<b>-14,201.4</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	521,846.3	507,644.9	-14,201.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>521,846.3</b>	<b>507,644.9</b>	<b>-14,201.4</b>

Авлага дансны 2019 оны эхний үлдэгдэл байгууллагаас авах авлага /НДШ/ 23.6 мянган төгрөг байсныг барагдуулж оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь:

- 2019 онд Бээжин, Турк, Сөүлийн 3 чиглэлээс Холер өвчинтэй 1, хамт явсан 18 нийт 19 хүнийг Олон улсад шуурхай тогтмол мэдээллэх, хөл хориот өвчин улсын хилээр дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангаж ажиллах,
- Баян-Өлгий аймагт гарсан тарваган тахлын голомтоос ирсэн ажилчдад бэлэн байдлыг хангуулах,
- улсын байцаагч, ажилтнуудын өдөр тутмын албан ажлын хэрэгцээний хангамжийн материалуудыг худалдан авах, гамшгаас хамгаалах хувцас хэрэгсэл, архивын улсын үзлэгтэй холбоотой хангамжийн материал авсан зэргээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2018 онд худалдаж авсан 2019 онд ашиглаагүй 2,818.9 мянган төгрөгийн 401 нэр төрлийн бараа материал байна. Энэ нь

эрүүл мэндийн асуудалтай холбоотой үүссэн онцгой байдлын үед ашиглах хамгаалах хэрэгсэл, маягт, бичиг хэрэгслийн материал байна.

Тайлант оны эцэст 1,894.3 мянган төгрөгийн 21 нэр төрлийн бараа материал худалдан авч нөөц үүсгэсэн нь байгууллагын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад зориулагдсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь ТӨБЗГ-ын 2019 оны 460 дугаар тогтоолоор Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох тогтоол гарсантай холбоотой 109,370.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг 1-4 жилээр сунган дахин үнэлж капиталжуулснаас шалтгаалжээ.

Мөн 4,239.9 мянган төгрөгийн энгэрийн камер, богино долгионы суурин станц, скайнер зэрэг хөрөнгийг Олон Улсын нисэх буудалд хяналт шалгалтын үйл ажиллагаанд зориулан цахим архив үүсгэхтэй холбогдуулан шаардлагатай үзүүлэлт бүхий тоног төхөөрөмжийн худалдан авалт хийжээ.

Хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан ТӨБЗГ-ын 2019 оны 27 дугаар тогтоолын дагуу "МИАТ" төрийн өмчит хувьцаат компаниас балансын үнэ 116,991.1 мянган төгрөг, хуримтлагдсан элэгдэл 27,514.5 мянган төгрөгийн 19-64УНЗ улсын дугаартай Janghuaai маркийн автобусыг хүлээн авч акт үйлдэн бүртгэлд тусгасан байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А-2/2532 дугаар албан бичгийн дагуу 2018 оны жилийн эцсийн тооллогоор ашиглах боломжгүй 27 нэр төрлийн 19,579.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд 85,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 109,065.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 128 хувиар биелүүлсэн байна.

Халдваргүйтгэлийн орлого 24,065.0 мянган төгрөгөөр давсан нь Авиакомпани болон Олон Улсын нислэгийн тоо нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,679,145.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,679,145.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,383,754.8 мянган төгрөг буюу 82.4 хувьтай байгаа нь нүүлгэн шилжүүлэлтийн ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 13,347.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснийг Менежментийн захидлаар зөвлөмж хүргүүллээ.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.



## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын алба нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 107,932.1 мянган төгрөгийн зөрчилд 2,018.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос төлбөрийг 100 хувь барагдуулсан, 56,023.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 49,890.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлснээс, МХЕГ-ын даргын 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн А/74 тоот тушаалын 3.а-д “Шинэ нисэх онгоцны буудал ажиллаж эхлэх хүртэл нэмэлтээр баталсан орон тоонд хүний нөөцийн томилгоо хийхгүй байх, зайлшгүй тохиолдолд төсвийн төвлөрүүлэн захирагчтай зөвшилцөн томилгоо хийх” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Зардлын данстай холбоотой асуудал**

3.1.1. Илрүүлэлт: Авто машин ашиглалтын хувийн хэрэг хөтлөөгүй, резин дугуй бусад эд анги норм норматив баримтлаагүй, явсан км тодорхойгүй байхад 5.970.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл олгосон нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралттай нийцээгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2. Эрсдэл: Төсвийн үргүй зардал гарах, хууль эрх зүйн акт зөрчигдөх

3.1.3. Өгсөн зөвлөмж: Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтыг мөрдөж ажиллах, авто машины хувийн хэргийг үнэн зөв хөтлөх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг цаашид мөрдөн ажиллана.

#### **3.2. Шатахууны зардалтай холбоотой асуудал**

3.2.1 Илрүүлэлт: Албан ажлын хэрэгцээний суудлын авто машины хоногт зарцуулах шатахууны нормыг 7,376.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Засгийн газрын 184 дүгээр тогтоолын 2 “Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор хуанлийн хоног (баярын болон долоо хоногийн амралтын өдрийг оролцуулан)-т дунджаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500 см<sup>3</sup>-ээс илүүгүй байхаар тогтоож, ажлын хоногт дунджаар 40 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай” заалттай нийцээгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

3.2.2. Эрсдэл: Төсвийн мөнгийг үр ашиггүй зарцуулах, холбогдох хууль эрх зүйн акт зөрчигдөх

3.2.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг цаашид мөрдөн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>114,848,938.24</b>	<b>125,884,434.67</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	23,583.17	-
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	23,583.17	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	114,825,355.07	125,884,434.67
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	5,475,968.04	10,121,330.54
35130	Эм боох материал	5,475,968.04	10,121,330.54
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	109,349,387.03	115,763,104.13
35410	Бичиг хэргийн материал	6,258,384.90	7,552,568.00
35420	Аж ахуйн материал	2,297,521.00	925,852.00
35440	Түлш, шатах тослох материал	10,328,078.00	10,444,281.00
35470	Бусад хангамжийн материал	90,465,403.13	96,840,403.13
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>406,997,360.64</b>	<b>381,760,484.21</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	406,997,360.64	381,760,484.21
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	406,997,360.64	381,760,484.21
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,443,847.00	194,434,897.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	73,308,251.89	120,432,075.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,214,513,212.14	1,313,003,910.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	943,893,313.02	1,116,672,163.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,077,191.40	62,927,001.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	23,618,159.42	23,881,954.94
39214	Бусад үндсэн хөрөнгө	186,718,903.00	184,408,903.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	95,936,068.57	112,028,033.81
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	-
39301	Програм хангамж	1,002,478.00	1,002,478.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	1,002,478.00	1,002,478.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>521,846,298.88</b>	<b>507,644,918.88</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>521,846,298.88</b>	<b>507,644,918.88</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	521,846,298.88	507,644,918.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	287,715,051.72	287,715,051.72
51101	Өмч: - төрийн	287,715,051.72	287,715,051.72
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	225,195,299.39	210,993,919.39
51210	Өмнөх үеийн үр дүн	285,692,829.43	225,195,299.39
51220	Тайлант үеийн үр дүн	(60,497,530.04)	(14,201,380.00)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,935,947.77	8,935,947.77
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>521,846,298.88</b>	<b>507,644,918.88</b>

**4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,569,022,538.16</b>	<b>1,990,311,996.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>111,901,138.16</b>	<b>311,166,896.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	111,901,138.16	311,166,896.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	111,855,138.16	311,019,396.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	104,955,000.00	109,065,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	514,800.67	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,385,337.49	201,954,396.00
120009	Бусад орлого	46,000.00	147,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,457,121,400.00</b>	<b>1,679,145,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,457,121,400.00	1,679,145,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,457,121,400.00	1,679,145,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,629,520,068.20</b>	<b>2,004,513,376.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,629,520,068.20</b>	<b>2,004,513,376.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,175,710,191.32	1,593,963,248.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	700,629,596.37	1,105,147,209.00
210101	Үндсэн цалин	633,652,396.37	853,785,109.00
210102	Нэмэгдэл	35,765,600.00	205,987,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,955,000.00	45,375,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,256,600.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	84,295,468.25	141,855,785.00
210201	Тэтгэврийн даатгал	48,262,368.25	88,696,085.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,008,300.00	13,289,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,206,600.00	10,631,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,801,700.00	2,658,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,016,500.00	26,579,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	43,846,450.00	51,199,000.00
210301	Гэрэл, цахилгаан	958,500.00	1,038,500.00
210304	Байрны түрээс	42,887,950.00	50,160,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,845,801.23	42,091,376.90
210401	Бичиг хэрэг	12,524,487.35	13,693,803.20
210402	Тээвэр, шатахуун	11,159,323.00	19,623,397.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,405,277.00	5,739,049.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,663,214.00	2,548,604.00
210408	Бараа материал акталсны зардал	4,093,499.88	486,523.70
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	5,654,098.31	5,720,905.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,351,182.32	3,673,620.50
210502	Хоол, хүнс	2,302,915.99	2,047,285.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	52,201,106.80	6,819,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,737,000.00
210604	Урсгал засвар	52,201,106.80	5,082,200.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	702,000.00	-
210702	Дотоод албан томилголт	702,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,558,010.00	7,931,513.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,248,700.00	4,261,645.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	167,400.00	600,568.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,500.00	202,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,015,410.00	2,009,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		536,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	241,977,660.36	233,198,259.43
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,143,535.00	4,875,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	235,834,125.36	228,323,259.43
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	453,809,876.88	410,550,127.17
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	32,885,904.00	6,094,904.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	958,414.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,927,490.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,094,904.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	420,923,972.88	404,455,223.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	420,923,972.88	404,455,223.17
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(60,497,530.04)</b>	<b>(14,201,380.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(60,497,530.04)</b>	<b>(14,201,380.00)</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,562,076,400.00</b>	<b>1,788,210,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>104,955,000.00</b>	<b>109,065,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>104,955,000.00</b>	<b>109,065,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	104,955,000.00	109,065,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	104,955,000.00	109,065,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,457,121,400.00</b>	<b>1,679,145,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,457,121,400.00</b>	<b>1,679,145,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,457,121,400.00	1,679,145,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,474,046,400.00</b>	<b>1,783,970,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,474,046,400.00</b>	<b>1,783,970,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,018,194,737.12</b>	<b>1,373,264,976.83</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>692,555,047.12</b>	<b>1,105,123,625.83</b>
210101	Үндсэн цалин	625,577,847.12	853,761,525.83
210102	Нэмэгдэл	35,765,600.00	205,987,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,955,000.00	45,375,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,256,600.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>91,701,757.00</b>	<b>141,855,785.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	55,668,657.00	88,696,085.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,008,300.00	13,289,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,206,600.00	10,631,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,801,700.00	2,658,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,016,500.00	26,579,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглагттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,418,000.00</b>	<b>51,199,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	958,500.00	1,038,500.00
210304	Байрны түрээс	42,459,500.00	50,160,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,082,613.00</b>	<b>40,902,247.00</b>
210401	Бичиг хэрэг	11,675,876.00	12,393,210.00
210402	Тээвэр, шатахуун	18,922,400.00	19,751,000.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	5,833,727.00	5,739,049.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,650,610.00	3,018,988.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,722,810.00</b>	<b>10,165,470.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,472,810.00	7,915,470.00
210502	Хоол, хүнс	2,250,000.00	2,250,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>127,714,000.00</b>	<b>7,970,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,300,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	73,610,200.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	51,803,800.00	5,970,800.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>702,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	702,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,976,010.00</b>	<b>11,173,049.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,248,700.00	4,729,189.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	167,400.00	600,568.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,500.00	202,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,015,410.00	3,001,092.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	418,000.00	2,318,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,322,500.00</b>	<b>4,875,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,322,500.00	4,875,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>455,851,662.88</b>	<b>410,705,223.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,927,690.00</b>	<b>6,250,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,200.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,927,490.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,250,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>420,923,972.88</b>	<b>295,390,223.17</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	420,923,972.88	295,390,223.17
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>109,065,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		109,065,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>88,030,000.00</b>	<b>4,239,900.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>88,030,000.00</b>	<b>4,239,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>88,030,000.00</b>	<b>4,239,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>88,030,000.00</b>	<b>4,239,900.00</b>
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	88,030,000.00	4,239,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(88,030,000.00)</b>	<b>(4,239,900.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	287,715,051.72	8,935,947.77	285,692,829.43		582,343,828.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	287,715,051.72	8,935,947.77	285,692,829.43	0.00	582,343,828.92
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайланг үеийн үр дүн			-60,497,530.04		-60,497,530.04
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	287,715,051.72	8,935,947.77	225,195,299.39	0.00	521,846,298.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	287,715,051.72	8,935,947.77	225,195,299.39	0.00	521,846,298.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайланг үеийн үр дүн			-14,201,380.00		-14,201,380.00
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	287,715,051.72	8,935,947.77	210,993,919.39	0.00	507,644,918.88

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,679,145,100.00	1,383,754,876.83
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,679,145,100.00	1,383,754,876.83
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,651,597,200.00	1,377,504,876.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,328,995,900.00	1,105,123,625.83
210101	Үндсэн цалин	1,077,633,800.00	853,761,525.83
210102	Нэмэгдэл	205,987,100.00	205,987,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,375,000.00	45,375,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	166,124,300.00	141,855,785.00
210201	Тэтгэврийн даатгал	112,964,600.00	88,696,085.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,289,900.00	13,289,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,631,900.00	10,631,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,658,000.00	2,658,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,579,900.00	26,579,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	56,074,500.00	51,199,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,038,500.00	1,038,500.00
210304	Байрны түрээс	55,036,000.00	50,160,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	52,371,900.00	40,902,247.00
210401	Бичиг хэрэг	13,132,600.00	12,393,210.00
210402	Тээвэр, шатахуун	19,751,000.00	19,751,000.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	15,841,500.00	5,739,049.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,106,800.00	3,018,988.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	14,409,600.00	10,165,470.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,159,600.00	7,915,470.00
210502	Хоол, хүнс	2,250,000.00	2,250,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,210,700.00	12,210,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,239,900.00	4,239,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	5,970,800.00	5,970,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,535,300.00	11,173,049.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,736,500.00	4,729,189.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	769,100.00	600,568.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,000.00	202,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,205,700.00	3,001,092.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,300,000.00	2,318,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,875,000.00	4,875,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,875,000.00	4,875,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27,547,900.00	6,250,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	27,547,900.00	6,250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,297,900.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,250,000.00	6,250,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	378.00	376.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	125.00	124.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	116.00	115.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00



**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<i>Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020.02.20			САГ-2020/62/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын алба</i>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Авто машины резин дугуй болон бусад үндсэн эд ангийг солихдоо норм баримтлаагүй, явсан км-ийг тодорхойлж, техникийн хувийн хэргийг хөтлөөгүй	6.0	Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн	Дарга Нягтлан бодогч	Б.Отгонцэцэг П.Оюунгэрэл
2	Албан ажлын хэрэгцээний суудлын авто машины хоногт зарцуулах шатахууны нормыг баримталж ажиллаагүй	7.4	Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн	Дарга Нягтлан бодогч	Б.Отгонцэцэг П.Оюунгэрэл





